


**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үндсэн  
эрхийн маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэрт  
тохирсон байх /Principle of Proportionality/ зарчмыг  
хэрэглэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ**

**An Analysis of the Application of the Principle of  
Proportionality in the Decision of the Constitutional  
Court of Mongolia Regarding Fundamental Rights Disputes**

*Зоригтын Янжиндулам*

*Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.)  
Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын  
Хууль зүйн газрын мэргэжилтэн  
Улаанбаатар хот, Монгол Улс.  
[yanjindulamzorigt@gmail.com](mailto:yanjindulamzorigt@gmail.com)*

© Z.Yanjindulam, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International  
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

**[Товч утга]**

Монгол Улсын Үндсэн хуульд заасан туйлын эрхээс бусад эрхийг хязгаарлахад тохирсон байх зарчимд нийцсэн байх шаардлага тавигддаг. Энэ хүрээнд Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэг бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн цэц үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэхдээ маргаан бүхий хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь тохирсон байх зарчимд нийцсэн эсэхийг тогтоох учиртай. Иймд тохирсон байх зарчмын тухай ойлголт, түүний үндсэн элемент, тус зарчмыг Монгол Улсад хэрхэн хэрэглэж ирсэн болон Үндсэн хуулийн цэц үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэхдээ тус зарчмыг хэрэглэсэн байдалд дүн шинжилгээ хийхэд энэхүү судалгаа чиглэгдсэн болно.

**[Түлхүүр үг]**

Тохирсон байх зарчим, Пропорциональ зарчим, Үндсэн хуулийн цэц, Үндсэн эрхийн маргаан.

## **I. Оршил**

Үндсэн хуулиар хамгаалсан туйлын эрхээс бусад эрхийг хязгаарлахад Үндсэн хуульд заасан хүний эрхийг хязгаарлахад тавигдах гол нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Хүний эрхийг хязгаарлахад тавигдах нэг гол нөхцөл нь тохирсон байх зарчим / principle of proportionality/ юм. Энэхүү зарчим нь хууль дээдлэх, шударга ёсны зарчмаас эхтэй бөгөөд хүний эрхийг хязгаарлахад хууль ёсны зорилготой байх, хязгаарлалт болон зорилго нь хоорондоо уялдаатай байх, хязгаарлалт нь зайлшгүй байх, тэнцвэртэй байх гэсэн үндсэн дөрвөн шалгуураар тодорхойлогдож, хэрэглэгддэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэгтэйн хувьд иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэдэг. Ийнхүү үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг шийдвэрлэхдээ дээрх тохирсон байх зарчмын дагуу шалгуур хангасан эсэхийг дүгнэж, үндэслэл бүхий хариулах шаардлагатай юм. Энэ хүрээнд энэхүү судалгаагаар тохирсон байх зарчмын ойлголтыг тодорхойлж, Үндсэн хуулийн цэцээс иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэхдээ тохирсон байх зарчмыг хэрэглэх шаардлагыг хэрхэн хангаж байгааг судлахыг зорилоо.

## **II. Тохирсон байх зарчмын онолын үндэс**

Судалгааны тус хэсэгт тохирсон байх зарчмын суурь ойлголт, түүний үүсэл, бусад улсад энэхүү зарчмыг хэрхэн хэрэглэдэг болохыг харьцуулан судалсны үндсэн дээр тус зарчмын үндсэн шалгууруудыг тодорхойлно.

### **A. Тохирсон байх зарчмын ойлголт, түүний үүсэл хөгжил**

Үндсэн хуулиар хамгаалсан туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлахад наад зах нь дараах зургаан гол нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хууль тавьдаг. I. хүний эрхэд тавьж буй аливаа хязгаарлалтыг хуульд тодорхой заах; II. хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байх; III. хязгаарлалт нь эдгээр зорилгын нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон байх (proportionality); IV. үндсэн эрхийг аль болох эдлүүлэх; V. ялгаварлан гадуурхахгүй байх; VI. хараат бус шүүхээр хянагддаг байх.<sup>1</sup> Үүнээс үзвэл тохирсон байх зарчим нь хүний эрхийн хязгаарлалтад тавигдах гол нөхцөлийн нэг болно. Тохирсон байх зарчмын хүрээнд аливаа үндсэн эрхэд

---

<sup>1</sup> О.Мөнхсайхан. “Туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл,” Хүний эрх: Өгүүлэл, илтгэл, санал, I боть дотор Уб., 2023. 22.

халдсан хязгаарлалтыг зөвтгөх нь хууль дээдлэх зарчмын нэг хэсэг юм.<sup>2</sup> Иймд төрөөс хүний эрхийг хязгаарласан хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагаа явуулах тохиолдолд тэр нь тохирсон байх зарчимд нийцсэн байна.

Хүний эрхийг хязгаарласан хууль нь ихэвчлэн тохирсон зарчмыг хангасан байдаг. Шүүхээс “хүний эрх”-д халдсан аливаа үйлдэл нь төрөөс тодорхойлсон хууль ёсны зорилгод нийцэж байгаа эсэх, түүнчлэн тухайн эрхийг хязгаарлаж буй төрийн үйл ажиллагаа нь тэрхүү зорилготой учир шалтгааны холбоотой эсэхийг үнэлэхийн тулд энэхүү зарчмыг ашигладаг. Хэрэв эдгээр хоёр нөхцөлийг хангаж байвал дараагийн алхам нь хүний эрхийг багаар хязгаарласан өөр бусад арга хэрэгсэл байж болох эсэхийг шалгах юм.<sup>3</sup> Төрөөс хүний эрхийг хязгаарласан аливаа хууль тогтоомж, шийдвэр нь тохирсон байх зарчимд нийцсэн эсэхийг бусад улсад ердийн шүүх болон үндсэн хуулийн шүүх нь хянан шийдвэрлэдэг бөгөөд тохирсон байх зарчмыг тухайлсан шалгуур болгон шийдвэрлэдэг байна. Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Канад, Өмнөд Африк зэрэг улсад үндсэн эрхийг зөрчсөн эсэхийг шийдвэрлэхэд үндсэн хуулийн шүүхээс тохирсон байх зарчмыг түгээмэл хэрэглэдэг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн шүүх нь тохирсон байх зарчмыг хууль дээдлэх ёсыг хангахад чухал ач холбогдолтой гэж үздэг бөгөөд энэхүү зарчмыг гурван талт шалгуураар хэрэглэдэг. Нэгдүгээрт, төрийн үйл ажиллагаа нь өөрийн тавьсан зорилгодоо хүрч чадахуйц байх ёстой. Хоёрдугаарт, төрийн үйл ажиллагаа энэ зорилгод үр дүнтэй хүрэхэд зайлшгүй шаардлагатай хэмжээнээс хэтэрч болохгүй. Гуравдугаарт, хэрэв тухайн зорилгод хүрэхийн тулд эрхийг хязгаарлах золиос нь тавьсан зорилготой тохирохооргүй бол төрийн байгууллага өөр үед хууль ёсны байж болох тэрхүү зорилгыг хэрэгжүүлэх ёсгүй гэж тайлбарладаг.<sup>4</sup>

Канадын шүүхээс хуулиар тогтоосон хязгаарлалт нь үндэслэлтэй эсэхийг тодорхойлохын тулд дараах хоёр үндсэн шалгуурыг хангасан байх ёстой гэж тогтоосон. Нэгдүгээрт, уг хязгаарлалтын зорилго нь үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг үгүйсгэх хангалттай ач холбогдолтой байх ёстой. Хоёрдугаарт, хангалттай чухал зорилгын төлөө түүнийг хязгаарлаж буй тал сонгосон арга хэрэгсэл нь үндэслэлтэй гэдгийг нотлох ёстой. Энэ нь хувь хүнийхтэй нийгмийн

<sup>2</sup> Werner Heun, *The Constitution of Germany: A Contextual Analysis* (2011), 206.

<sup>3</sup> Conor Gearty. “Human Rights Law,” in Roger Masterman and Robert Schütze, *The Cambridge Companion to Comparative Constitutional Law* (2022), 310.

<sup>4</sup> Юрген Броне. “Германы Үндсэн хуулийн эрх зүй, үндсэн эрхийн номлолын оршил,” *ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл: үндсэн эрх* дотор (МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, 2023) 14.

ашиг сонирхол тэнцвэртэй байх тохирсон байдлын шалгалтыг хамардаг. Тохирсон байдлын төстийн гурван чухал бүрэлдэхүүн хэсэг нь: (I) Хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн зорилгодоо хүрэхийн тулд сайтар боловсруулсан байх ёстой. Эдгээр нь дур зоргоороо, шударга бус эсвэл үндэслэлгүй байж болохгүй. Товчхондоо, тэрхүү зорилгодоо хүрэхэд уялдаатай байх ёстой. (II) Зорилгодоо хүрэхэд чиглэсэн арга хэрэгсэл нь тухайн эрх, эрх чөлөөнд аль болох бага халдсан байх ёстой. (III) Эрх, эрх чөлөөг хязгаарлах үүрэгтэй арга хэмжээний үр нөлөө болон “хангалттай ач холбогдолтой” гэж тодорхойлсон зорилгын хооронд тэнцвэртэй байх ёстой гэж үздэг.<sup>5</sup> Эдгээрээс үзвэл зарим улсад эрхийн хязгаарлалт нь тохирсон байх зарчимд нийцсэн эсэхийг ердийн шүүх, үндсэн хуулийн шүүхээс хянахдаа тус зарчмын үндсэн бүрэлдэхүүнийг тодорхойлж шалгадаг байна. Иймд энэхүү судалгааны дараагийн хэсэгт тохирсон байх зарчмын үндсэн шалгуур, түүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц хэрхэн тодорхойлсныг судална.

### **Б. Тохирсон байх зарчмын үндсэн бүрэлдэхүүн**

Судалгааны энэхүү хэсэгт тохирсон байх зарчмын үндсэн шалгуурыг онолын болон Үндсэн хуулийн цэцийн маргаан шийдвэрлэсэн шийдвэрийг үндэслэн тодорхойлохыг зорилоо.

Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь тохирсон байх зарчим нь онолын болон хэм хэмжээний үүднээс дараах дөрвөн шалгуурыг хангасан байна:

Нэг дэх шалгуур нь хууль ёсны зорилготой байх: Үндсэн эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой байх ёстой. Жишээлбэл, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж заасан бөгөөд энэ нь хүний эрхийг хязгаарлах Үндсэн хуулийн зорилгыг тодорхойлсон явдал гэж үзэж болохоор байна. Эндээс үндсэн эрхийг эдгээр хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор л хязгаарлаж болно гэдэг нь харагдана. Энэхүү шалгуурыг Үндсэн хуулийн цэцээс тохирсон байх зарчмын нэгэн шалгуур болохыг тогтоосон бөгөөд “Үндсэн эрхийн хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой байх бөгөөд уг хязгаарлалт болон зорилго нь хоорондоо уялдаатай байна.” гэж тухайлан тайлбарлажээ.<sup>6</sup>

<sup>5</sup> Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence* (2002), 796.

<sup>6</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт (2024.06.12, №03)

Хоёр дахь шалгуур бол эрхийн хязгаарлалт хууль ёсны зорилго уялдсан байх зарчим. Эрхийг хязгаарласан арга хэмжээ болон хууль ёсны зорилго хоёр хоорондоо уялдсан байх ёстой. Хязгаарлалт нь хууль ёсны зорилгод үйлчлэх, ухаалгаар холбогдож байхыг энэхүү шалгуураар шаарддаг. Өөрөөр хэлбэл, үндсэн эрхийг хязгаарлахад хүргэсэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлснээр тавигдсан хууль ёсны зорилгод хүрэх боломжтой гэдгийг тогтоох ёстой.<sup>7</sup> Үүнийг Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэрт “Хязгаарлалт нь зорилгыг хэрэгжүүлэхэд үйлчлэх буюу чиглэсэн байхыг уялдаатай байх зарчим шаардана. Төрөөс тодорхой зорилгод хүрэхийн тулд ямар арга хэмжээ авч болохыг тодорхойлоход сонголт хийх өргөн боломжтой боловч тухайн сонголт нь тэрхүү зорилгод хүрэхэд үйлчилж, уялдсан байхын зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон нөхцөл, шалгуурт нийцсэн байвал зохино.” гэж тодорхойлжээ.<sup>8</sup>

Гурав дахь шалгуур бол хязгаарлалт нь зайлшгүй байх зарчим. Энэхүү зарчмыг Үндсэн хуулийн цэцээс “Зорилгод хүрэхийн тулд авч болох боломжит, үр дүнтэй арга хэмжээнүүдээс ижил үр дүнтэй боловч үндсэн эрхэд хамгийн бага халдсан арга хэмжээг нь сонгохыг энэ зарчим шаардана. Мөн зорилгын үүднээс үндсэн эрхийг хэт өргөн хүрээнд хязгаарлах, үндсэн эрхийн хэрэгжилтийг аль нэг албан тушаалтны үзэмж, дур мэдлээс хэт хамааралтай болгохоос татгалзах бөгөөд хязгаарлалт нь үндсэн эрхийн цөмийг үгүйсгээгүй байх, хуулийн талаарх өөр өөр тайлбаруудаас үндсэн эрхэд илүү нийцээнийг нь хэрэглэх зэрэг агуулга үүнд хамаарна.” гэж үзсэн.<sup>9</sup>

Дөрөв дэх шалгуур нь тэнцвэрийн зарчим юм. Энэ зарчим нь хууль ёсны зорилгыг хангах шаардлага болон хөндөгдөж буй эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоёрын тэнцвэрийг олсон эсэхийг шалгана.<sup>10</sup> Энэхүү шалгуурыг “үндсэн эрхийг хязгаарласнаар хангагдах ашиг сонирхол нь халдаж буй эрхийг хамгаалах ашиг сонирхлоос дээгүүр байвал тухайн хязгаарлалт нь хууль дээдлэх ёсны үүднээс зөвтгөгдөх боломжтой. Харин зорилгод хүрэх цорын ганц арга нь хэт өндөр үнээр хэрэгжих тохиолдолд тухайн аргыг хууль ёсны байсан ч ашиглаж болохгүй.” гэж тодорхойлсон байна.<sup>11</sup>

<sup>7</sup> Юрген Бромер, “Германы Үндсэн хуулийн эрх зүй, үндсэн эрхийн номлолын оршил,” *ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл: үндсэн эрх* дотор (МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, 2023) 25.

<sup>8</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт (2024.06.12, №03)

<sup>9</sup> Мөн тэнд.

<sup>10</sup> Петер Казиске, *Эрх зүйн онолын ерөнхий, тусгай зарчмууд, түүний хэрэглээ, сургалтын гарын авлага* (УБ, 2024), 61.

<sup>11</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар

Дээрхээс үзвэл тохирсон байх зарчим нь үндсэн эрхийг хязгаарлах тохиолдолд хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх, хязгаарлалт болон зорилго нь хоорондоо уялдаатай байх, хязгаарлалт нь зайлшгүй байх, тэнцвэртэй байх гэсэн үндсэн дөрвөн шалгууртай байна. Ийнхүү судалгааны дараагийн бүлэгт Монгол Улсад тохирсон байх зарчмыг эрх зүйн хэм хэмжээ, холбогдох шийдвэрт хэрхэн тодорхойлж хэрэглэж ирсэн болон Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт тохирсон байх зарчмыг хэрэглэсэн байдалд дүн шинжилгээ хийнэ.

### **III. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт тохирсон байх зарчмыг хэрэглэх нь**

Судалгааны энэ хэсэгт тохирсон байх зарчмыг Монгол Улсын хууль тогтоомжид тусгаж байсан эсэх, хүний эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэдэг, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоож, сэргээн эдлүүлэх эрх бүхий ердийн шүүх хэрэглэдэг эсэх, Үндсэн хуулийн цэцээс үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэхдээ тохирсон байх зарчмыг хэрхэн хэрэглэсэн байдалд дүн шинжилгээ хийх болно.

#### **A. Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал**

Тохирсон байх зарчмыг Үндсэн хуулийн цэц, ердийн шүүх хүний эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэхэд ашиглахаас гадна холбогдох хууль тогтоомжид ч тусгаж ирсэн түүхтэй. Тухайлбал, Иргэний хууль (2002)-ийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Өөртөө туслах үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон хэр хэмжээнээс хэтэрч болохгүй.” гэж, Эрүүгийн хууль (2015)-ийн 1.3 дугаар зүйлд “Шударга ёсны зарчим” гээд 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.”, Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)-ийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт “Энэ хуулийн 10.4-т заасны дагуу гарах аливаа шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд доор дурдсан шаардлагыг нэг мөр хангана.” гээд 10.9.3 дахь заалтад “энэ хуулийн 10.9.2-т заасан зорилгод хүрэхэд зайлшгүй, тухайн нөхцөлд тохирсон, тодорхой хүрээ, хугацаатай байх;”, Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 1.3 дугаар зүйлд “Шударга ёсны зарчим” гээд 1 дэх хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь

---

зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт (2024.06.12, №03)

зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.”, *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (2020)-ийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Энэ хуульд заасан арга хэмжээ нь тухайн нөхцөлд тохирсон тодорхой хамрах хүрээ, хугацаатай байх бөгөөд цугларсан мэдээллийг нийгмийн эрүүл мэндийг хамгаалахаас бусад зорилгоор ашиглах, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхийг хориглоно.”*, мөн зүйлийн 11.4 дэх хэсэгт “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байна.”, Улс төрийн намын тухай хууль (2023)-ийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй, тохирсон бөгөөд хуульд зааснаас өөр хязгаарлалтыг эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон холбогдох бусад үндсэн эрх, эрх чөлөөг эдлэхэд тавьж үл болно.” гэж тусгайлан хуульчилсан байна.

Хууль тогтоомж төдийгүй эрх бүхий байгууллагын шийдвэрт тохирсон байх зарчмыг мөн хэрэглэж иржээ. Тодруулбал, Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар” 31 дугаар тогтоолд “Эд мөрийн баримтыг олж илрүүлэх, хураан авах ажиллагаа явуулах үндэслэл нь прокурорын зөвшөөрөл бөгөөд тухайн ажиллагааг явуулах хуульд заасан үндэслэл бүрдсэн эсэх, хувийн халдашгүй байх эрхийн хязгаарлалт нь тухайн нөхцөл байдалд тохирсон эсэхийг прокурор зөвшөөрөл олгохдоо хянан үзэх үүрэгтэй.” гэж тайлбарласан бол Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 22 дахь илтгэлд удаа дараа дурдаж, хэрэглэсэн байна.

Дээрхээс үзвэл тохирсон байх зарчмын хэрэглээ нь Монгол Улсын хувьд шинэлэг ойлголт биш бөгөөд хууль тогтоомж төдийгүй эрх бүхий этгээдийн шийдвэрт хэрэглэж ирсэн зарчим юм. Ийнхүү тохирсон байх зарчмын агуулгыг эрхийн хязгаарлалт нь тухайн нөхцөл байдалд тохирсон, хэмжээ хэтрээгүй, зайлшгүй байх зэрэг агуулгаар тайлбарлаж хэрэглэдэг байна. Иймд энэхүү судалгааны дараагийн хэсэгт Үндсэн хуулийн цэцийн үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэрт тохирсон байх зарчмыг хэрэглэж, тайлбарласан байдалд дүн шинжилгээ хийх болно.

## **Б. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт тохирсон байх зарчмыг хэрэглэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ**

Дээр дурдсанчлан Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхтэйн хувьд үндсэн эрхийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэнэ. Энэ хүрээнд хууль тогтоомж, эрх бүхий этгээдийн шийдвэр үндсэн эрхийг хязгаарласан нь тохирсон байх зарчимд нийцсэн эсэхийг шалгах шаардлагатай бөгөөд Үндсэн хуулийн цэцээс үндсэн эрх зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэж ирсэн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар тохирсон байх зарчмын хэрэглээг энэхүү хэсгээр судална. Ингэхдээ “үндсэн эрх” зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан үндсэн эрх, эрх чөлөө болон тэдгээртэй адилтгах эрхийг зөрчсөн эсэхээр тодорхойлж сонгон авна.<sup>12</sup> Харин Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг сүүлийн таван жил буюу 2020 оноос эхлэн одоог хүртэлх гарсан шийдвэрийн хүрээгээр хязгаарлаж шинжилнэ. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэсэн эсэхээр шалгуур болгон сонгоход 2020 оноос хойш 25 шийдвэр гаргасныг дараах хэсэгт тус бүрд нь задлан шинжилж, холбогдох хэсгийг тодруулж тусгалаа. Үүнд:

### **1. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоол**

*Хууль ёсны зорилготой байх:* “Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтад цагдаагийн алба хаагчийг үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг хориглосон нь ... Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1, Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад тус тус заасны дагуу **хууль ёсны зорилго гэж үзэхээр байна.**”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* “хориглосон нь уг хуулийн 4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах **зорилгыг хэрэгжүүлэхэд үйлчлэхээр байх**”

*Зайлшгүй байх:* “Нэгэнт холбогдох хууль тогтоомжоор **хөдөлмөрлөх харилцааны хүрээнд үйлдвэрчний эвлэлд нэгдэх,**

<sup>12</sup> Үндсэн эрх, эрх эрх чөлөөтэй “адилтгах эрх” гэдгийг Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Зургадугаар зүйлийн 3, 5 дахь хэсэг, Долдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөв, Арван тавдугаар зүйл, Арван наймдугаар зүйлийн 5 дахь хэсэг, Арван ес дүгээр зүйл, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гучин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Тавин хоёр, Тавин гурав, Тавин дөрөв, Тавин тав дугаар зүйлд заасан эрх, мөн Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”-ийг ойлгоно.

хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажил хаях эрхийг хориглосон байх тул эвлэлдэн нэгдэх **үндсэн эрхэд хамгийн бага халдсан гэж үзэх үндэслэлгүй** байна.”

*Тэнцвэрийг хангасан байх:* “үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхийг бүхэлд нь үгүйсгэхийн ач холбогдол нь тухайн үгүйсгэж буй эрхийн хамгаалалтаас илүү дээгүүр гэж үзэх үндэслэлгүй тул **тэнцвэрийн зарчим хангагдаагүй** байна.”

2. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* “Хүний алдар хүндээ эрхэмлэх мөн чанартай нь холбогдуулан эрсдэлтэй буюу татвар төлөхөөс зугтдаг, татварын өр төлөхөөс зайлсхийдэг татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх зохицуулалтыг хуульчилсан нь хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгах сэдлийг нэмэгдүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх явдлыг таслан зогсоох **зорилготой гэх үндэслэлтэй юм.**”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* “нийтэд мэдээлэх нь бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, татвар төлөгчийг эрсдэлээс сэргийлэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх болон хуулиар ногдуулсан албан татвар төлөх иргэний үндсэн үүргийг биелүүлэхэд чиглэсэн төрийн **хууль ёсны зорилгод уялдсан байна.**”

*Зайлшгүй байх:* “эрхийн хязгаарлалтыг албан тушаалтны дур мэдэлд үлдээж, татвар төлөгчийн талаар ямар ч мэдээллийг нийтэлж болохоор, эсхүл урьдач нөхцөлийг хангасан ч нийтлэхгүй байж болохоор хэт өргөн хүрээтэй хязгаарласан, татвар төлөгчийн талаар нийтлэгдсэн мэдээлэл бодитой, үнэн зөв биш тохиолдолд мэдээлэлд засвар оруулах процессын хамгаалалтыг татвар төлөгчид олгоогүй, эрхийг хязгаарлах хуулийн үндэслэл, нөхцөл үгүй болсноор нийтэд дэлгэсэн мэдээллийг устгах хуулийн хязгаарлалт тогтоогоогүй зэрэг нь үндсэн эрхийн хязгаарлалт явцуу хүрээтэй байх, үндсэн эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах **зайлшгүй байх зарчимд нийцэхгүй байна.**”

*Тэнцвэрийг хангасан байх:* “нийтийн ашиг сонирхлыг хангах зорилготой боловч хувийн мэдээллийг нь нийтэд мэдээлэх замаар хүний алдар хүндэд халдсанаар **тэнцвэртэй байх зарчим алдагдсан байна.**”

3. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* “Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн түр саатуулах ажиллагаа нь уг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ... **хууль ёсны зорилго мөн**

байна.”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* “хүнийг түр саатуулж болох 6 цаг хүртэлх хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцох журам нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгод үйлчлэхээр байгаа тул уг зохицуулалт болон **зорилго нь хоорондоо уялдаатай байна.**”

*Зайлишгүй байх:* “эрх чөлөөнд хамгийн бага халдсан зохицуулалт биш учраас дээр дурдсан зорилгод хүрэхэд **зайлшгүй байх зарчмыг хангахгүй байна.**”

*Тэнцвэрийг хангасан байх:* “гэмт хэрэгт холбогдоогүй байгаа хүнийг тус зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан хэт ерөнхий үндэслэлээр 6 цагаас илүү урт хугацаагаар түр саатуулах нь үүний цаана зөрчигдөж буй **бие махбодын эрх чөлөөнөөс дээгүүр ашиг сонирхол гэж үзэхээргүй байна.**”

4. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 02 дугаар дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* “Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтоох **зорилт бүхий** Цагдаагийн албаны тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтад цагдаагийн алба хаагч нь аливаа үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, үйл ажиллагааг нь сурталчлах, дэмжлэг үзүүлэхийг хориглохоор **хуульчилсан байна.**”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* “үндсэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болгон хуульчилсан нь **зорилгодоо нийцээгүй**”

*Зайлишгүй байх:* “Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын холбогдох зохицуулалтаар хэт өргөн хүрээнд энэхүү үндсэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болгон хуульчилсан нь зорилгодоо нийцээгүй, **хэмжээ хэтэрсэн буюу тохирсон байх зарчмыг алдагдуулсан гэж үзэхээр байна.**”

*Тэнцвэрийг хангасан байх:* Дүгнээгүй.

5. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр тогтоолд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

6. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар тогтоол

*Хууль ёсны зорилготой байх:* “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн зохицуулалт нь Үндсэн хууль зөрчсөн хэм

хэмжээг хэрэглэн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, Үндсэн хуульт ёс болон хууль дээдлэх зарчмыг баталгаажуулахад чиглэсэн хэм хэмжээ байх”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* Дүгнээгүй.

*Зайлшгүй байх:* Дүгнээгүй.

*Тэнцвэрийг хангасан байх:* Дүгнээгүй.

7. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* “Эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлэх хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад тусгасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах төрийн хууль ёсны зорилго мөн байна.”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* Дүгнээгүй.

*Зайлшгүй байх:* “Хүний хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг ийнхүү хязгаарлахгүйгээр уг хуулийн зорилгод хүрэх боломжтой байна.”

*Тэнцвэрийг хангасан байх:* “иргэний өөрийн болон гэр бүлийн халдашгүй байдал, хувийн нууцаа хамгаалах эрхийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн нь уг хуулийн зохицуулалтын зорилго биелснээр олж болох давуу талтай харьцуулахад илүү эрсдэл бүхий үр дагавартай байна.”

8. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

9. Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 02 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

10. Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01 дүгээр дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* “Шүүгчийн гүйцэтгэж байгаа мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдуулан, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг баталгаажуулах хүрээнд хийсэн дээрх хязгаарлалт”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* Дүгнээгүй.

*Зайлшгүй байх:* Дүгнээгүй.

*Тэнцвэрийг хангасан байх:* Дүгнээгүй.

11. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

12. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 01 дүгээр тогтоолд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

13. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 05 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

14. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

15. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

16. Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 01 дүгээр дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

17. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

18. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 10 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

19. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 09 дүгээр дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

20. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 08 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

21. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 07 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

22. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 05 дугаар дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* ““дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг үйлдсэн бол” гэсэн ойлголтыг гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг харгалзан түүнээс **урьдчилан сэргийлэх зорилгоор** таслан сэргийлэх тодорхой төрлийн арга хэмжээг авах **үндэслэл болгон хуульчилжээ.**”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх:* Дүгнээгүй.

*Зайлишгүй байх:* Дүгнээгүй.

*Тэнцвэрийг хангасан байх:* Дүгнээгүй.

23. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр тогтоолд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

24. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 03 дугаар дүгнэлт

*Хууль ёсны зорилготой байх:* “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсгийн зохицуулалт нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, **төрийн бодлогын хүрээнд хуульчлагдсан хязгаарлалт** гэж үзэхээр байх тул иргэний сонгогдох эрхийг бүх насаар нь хязгаарласан хэмээн

шууд дүгнэх үндэслэлгүй”

*Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх: Дүгнээгүй.*

*Зайлиггүй байх: Дүгнээгүй.*

Тэнцвэрийг хангасан байх: “Улсын Их Хурлын гишүүний албан тушаалын онцлогийг харгалзан ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлагыг хангахад чиглэгдсэн тусгай шалгуурыг нэр дэвшигчид хуулиар тогтоосон нь хууль тогтоогчийн онцгой бүрэн эрхэд хамаарч байна.”

25. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 02 дугаар дүгнэлтэд тохирсон байх зарчмыг хэрэглээгүй.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт тохирсон байх зарчмыг хэрэглэсэн эсэхийг дөрвөн үндсэн шалгуураар задалж дүгнэснийг контент шинжилгээний өгөгдөл цуглуулж, шинжлэх аргаар Хүснэгт 1-т нэгтгэн дүгнэхэд дараах үр дүн гаргалаа.

*Хүснэгт 1.*

*Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ*

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр	Хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх	Хязгаарлалт нь зорилгодоо уялдаатай байх	Хязгаарлалт нь зорилгод хүрэхэд зайлшгүй байх	Зорилгыг хангаснаар хүрэх үр дүн болон хөндөгдөж буй эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоорондын тэнцвэрийг хангасан байх
2024 оны 03 дугаар тогтоол	+	+	+	+
2024 оны 04 дүгээр дүгнэлт	+	+	+	+
2024 оны 03 дугаар дүгнэлт	+	+	+	+
2024 оны 02 дугаар дүгнэлт	+	+	+	-
2023 оны 04 дүгээр тогтоол	-	-	-	-
2023 оны 03 дугаар тогтоол	+	-	-	-
2023 оны 03 дугаар дүгнэлт	+	-	+	+
2023 оны 02 дугаар дүгнэлт	-	-	-	-
2022 оны 02 дугаар дүгнэлт	-	-	-	-
2022 оны 01 дүгээр дүгнэлт	+	-	-	-
2021 оны 07 дугаар дүгнэлт	-	-	-	-
2021 оны 01 дүгээр тогтоол	-	-	-	-
2021 оны 05 дугаар дүгнэлт	-	-	-	-

2021 оны 04 дүгээр дүгнэлт	-	-	-	-
2021 оны 02 дугаар дүгнэлт	-	-	-	-
2021 оны 01 дүгээр дүгнэлт	-	-	-	-
2020 оны 12 дугаар дүгнэлт	-	-	-	-
2020 оны 10 дугаар дүгнэлт	-	-	-	-
2020 оны 09 дүгээр дүгнэлт	-	-	-	-
2020 оны 08 дугаар дүгнэлт	-	-	-	-
2020 оны 07 дугаар дүгнэлт	-	-	-	-
2020 оны 05 дугаар дүгнэлт	+	-	-	-
2020 оны 01 дүгээр тогтоол	-	-	-	-
2020 оны 03 дугаар дүгнэлт	+	-	-	+
2020 оны 02 дугаар дүгнэлт	-	-	-	-
Нийт +/-	9	4	5	5
	23/100=23%			

Энэхүү дүн шинжилгээгээр тохирсон байх зарчмын үндсэн бүрэлдэхүүн болох хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх, хязгаарлалт болон зорилго нь хоорондоо уялдаатай байх, хязгаарлалт нь зайлшгүй байх, тэнцвэртэй байх гэсэн шалгуур тус бүрийг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт хэрэглэсэн байдлаар шалгаж, агуулгын хувьд дүгнэлт хийж үзлээ. Ийнхүү дүгнэхэд Үндсэн хуулийн цэцийн сүүлийн 5 жилийн хугацаанд шийдвэрлэсэн үндсэн эрх зөрчсөн эсэх маргааны 23 хувьд нь тохирсон байх зарчмын шалгуурыг хангасан эсэхийг дүгнэж шийдвэрлэсэн байна.

#### IV. Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь иргэний үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэхэд тохирсон байх зарчмыг хэрэглэж шийдвэр гаргах учиртай. Учир нь тохирсон байх зарчим нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хууль дээдлэх, шударга ёсны зарчмаас эхтэй тул Цэцийн шийдвэр үндэслэлтэй хуульд нийцсэн, бодитой байх шалгуурын үүднээс уг зарчмыг хэрэглэх нь зайлшгүй юм. Тохирсон байх зарчмыг хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх, хязгаарлалт болон зорилго нь хоорондоо уялдаатай байх, хязгаарлалт нь зайлшгүй байх, тэнцвэртэй байх гэсэн үндсэн дөрвөн шалгуураар тодорхойлж хэрэглэх явдал түгээмэл байх бөгөөд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Канад

зэрэг улсын Үндсэн хуулийн шүүх, ердийн шүүх нь энэхүү зарчмыг эрхийн хязгаарлалт үндэслэлтэй эсэхийг тогтооход хэрэглэдэг байна.

Ийнхүү Үндсэн хуулийн цэцийн үндсэн эрх зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн сүүлийн 5 жилийн шийдвэрт тохирсон байх зарчмыг хэрэглэсэн байдлыг тус бүрээр нь задлан дүгнэхэд 23 хувьд нь уг зарчмыг хэрэглэсэн гэх дүн гарсан. Энэ нь Цэцийн шийдвэрийн түвшинд хангалтгүй үзүүлэлт тул цаашид шийдвэрийн үндэслэгээг сайжруулах үүднээс үндсэн эрх зөрчигдсөн эсэхийг шийдвэрлэх маргаан бүрд энэхүү зарчмыг хэрэглэх шаардлагатай байна. Үндсэн хуулийн цэц нь 2024 онд гарсан үндсэн эрх зөрчсөн эсэх маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэртээ тохирсон байх зарчмыг дэлгэрүүлэн тайлбарлаж, шалгуур бүрээр нь дүгнэж үндэслэл бүхий шийдвэр бичиж буй нь дээрх судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иймд Үндсэн хуулийн цэц цаашид үндсэн эрх зөрчигдсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх бүртээ тохирсон байх зарчмыг хэрэглэж үндэслэлээ дэлгэрэнгүй тусгадаг байснаар тус зарчмын хэрэглээг зөвхөн ердийн шүүх төдийгүй хууль тогтоох, гүйцэтгэх эрх бүхий төрийн дээд байгууллагуудад таниулах, иргэдэд хүний эрхийн суурь ойлголт, түүнийг хязгаарлахад тавих үндсэн нөхцөлийг таниулахад чухал ач холбогдолтой байна.

[Ном зүй]

О.Мөнхсайхан, “Туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл,” Хүний эрх: Өгүүлэл, илтгэл, санал, I боть дотор (2023)

Юрген Бромер, “Германы Үндсэн хуулийн эрх зүй, үндсэн эрхийн номлолын оршил,” *ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл: үндсэн эрх* дотор (МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, 2023)

Петер Казиске, *Эрх зүйн онолын ерөнхий, тусгай зарчмууд, түүний хэрэглээ, сургалтын гарын авлага* (УБ, 2024)

Werner Heun, *The Constitution of Germany: A Contextual Analysis* (2011)

Conor Gearty, “Human Rights Law,” in Roger Masterman and Robert Schütze, *The Cambridge Companion to Comparative Constitutional Law* (2022)

Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence* (2002)

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн Хууль, (1940)

Монгол Улсын Үндсэн Хууль, (1992)

Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн тухай хууль, (1992)

Иргэний хууль (2002)

Эрүүгийн хууль (2015)

Захиргааны ерөнхий хууль (2015)

Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)

Зөрчлийн тухай хууль (2017)

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (2020)

Улс төрийн намын тухай хууль (2023)

Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 31 дугаар тогтоол “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөв хэрэглэх албан ёсны тайлбар”

Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 22 дахь илтгэл

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дараах дүгнэлт, тогтоолууд:

2024 оны “Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 03 дугаар тогтоол

2024 оны “Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 04 дүгээр дүгнэлт

2024 оны “Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн

эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 03 дугаар дүгнэлт

2024 оны “Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг 69 дүгээр зүйлийн 69.1.8 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт

2024 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 03 дугаар дүгнэлт

2023 оны “Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 04 дүгээр тогтоол

2023 оны “Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 03 дугаар дүгнэлт

2023 оны “Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт

2022 оны “Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт

2022 оны “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцсэн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай” 01 дүгээр дүгнэлт

2021 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 07 дугаар дүгнэлт

2021 оны “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 01 дүгээр тогтоол

2021 оны “Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 05 дугаар дүгнэлт

2021 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 04 дүгээр дүгнэлт

2021 оны “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.4, 5.6, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт

2021 оны “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 01 дүгээр дүгнэлт

2020 оны “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 12 дугаар дүгнэлт

2020 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлийн зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 10 дугаар дүгнэлт

2020 оны “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай” 09 дүгээр дүгнэлт

2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7.3 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 08 дугаар дүгнэлт

2020 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.2 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 07 дугаар дүгнэлт

2020 оны “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.2 дугаар зүйлийн 2, 14.5 дугаар зүйлийн 1, 14.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 05 дугаар дүгнэлт

2020 оны “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” 01 дүгээр тогтоол

2020 оны “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.9, 32.3.11 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 03 дугаар дүгнэлт

2020 оны “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлт

**[Abstract]**

**An Analysis of the Application of the Principle of Proportionality  
in the Decision of the Constitutional Court of Mongolia  
Regarding Fundamental Rights Disputes**

**Zorigt Yanjindulam**

*Bachelor of Laws (LL.B.)*

*Legal Officer at the Legal Department of the  
Secretariat of the Constitutional Court of Mongolia*

*Ulaanbaatar, Mongolia*

The principle of proportionality requires that any limitation on rights, except for absolute rights enshrined in the Constitution of Mongolia, must meet the criteria of proportionality. In this context, the Constitutional Court of Mongolia, which holds the supreme authority to oversee the enforcement of the Constitution, is tasked with determining whether laws, decisions, or actions of authorized officials in disputes concerning the violation of fundamental rights comply with the principle of proportionality. Accordingly, this study focuses on the concept of the principle of proportionality, its fundamental elements, its application in Mongolia, and the extent to which the Constitutional Court has applied this principle in adjudicating disputes regarding violations of fundamental rights.

**[Keywords]**

Principle of proportionality, Constitutional Court of Mongolia (Tsets), fundamental rights disputes.